



Australian Government
AusAID



Австрали Улсаас 2012-2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги

2013 оны 4-р сар



Хамтын нөхөрлөлийн сүлд болон өөрөөр тэмдэглэснээс бусад тохиолдолд энэ баримт бичигт танилцуулсан бүх материалыг Creative Commons Attribution 3.0 Australia (<http://creativecommons.org/licenses/by/3.0/au/>) лицензийн дагуу оруулсан болно. Холбогдох лицензийн нөхцлийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл Creative Commons-ын вэбсайтад (өгсөн холбоосыг ашиглан нэвтрэх боломжтой) байгаа бөгөөд мөн тэндээс CC BY 3.0 AU лицензийн хууль зүйн бүрэн кодыг (<http://creativecommons.org/licenses/by/3.0/au/legalcode>) авч болно. Австрали Улсаас 2012-2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөр, 2013 оны 4-р сар, PUB19 дугаар бүхий энэхүү баримт бичиг нь АОУХА-ийнх болно.

Нийтэлсэн: Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг (АОУХА), Канберра, 2013 оны 3-р сар.

Интернэтэд www.aid.gov.au/publications гэсэн хаягаар орж энэ баримт бичигтэй танилцах боломжтой.

Австралийн Засгийн газрын олон улсын хөгжлийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу:

Communications Section

AusAID

GPO Box 887

Canberra ACT 2601

Утас (02) 6178 4000

Факс (02) 6178 4880

Интернэт www.aid.gov.au

Агуулга

1	Хураангуй	5
2	Хөгжлийн түншлэлийн зарчмууд	8
2.1	Зарчим, үүрэг амлалт	8
2.2	Үр дүнд хамтран анхаарах нь	9
3	Австрали Улсаас Монгол Улсад үзүүлж буй тусламжийн орчин нөхцөл, үндэслэл	10
3.1	Ядуурал ба хэрэгцээ	10
3.2	Австралийн үндэсний эрх ашиг	12
3.3	Эерэг өөрчлөлт хийх чадавхи	12
3.4	Цар хүрээ ба үр ашиг	14
4	Австрали Улсын тусламжийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд	15
4.1	Голлон анхаарахаар санал болгож буй чиглэлүүд, хүлээж буй үр дүн ба Австрали улсаас оруулах хувь нэмэр	15
4.2	Хөтөлбөрийн хандлага ба хэрэгжих арга зам	17
5	Хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүн ба эрсдэлийн удирдлага	18
5.1	Стратегийг хэрэгжүүлж дуусахад ямар амжилтад хүрсэн байх вэ	18
5.2	Үр дүнгийн үнэлгээний механизм	18
5.3	Эрсдэлийн удирдлага	18
6	Лавлах материал	20

1 Хураангуй

Далайд гарцгүй, хүн ам сийрэг, байгалийн баялаг ихтэй Монгол Улс хөгжлийн өвөрмөц сорилтуудтай тулгарч байна. Монгол Улс ардчилсан, чөлөөт зах зээлийн тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн дэвшил гаргаж, эдийн засгаа өсгөснөөр дундаас доогуур орлоготой орны түвшинд очсон билээ. Гэхдээ тус улсад ядуурлын түвшин өндөр хэвээр буюу нийт хүн амын 39 хувийг, (ойролцоогоор 1 092000 хүн) хамарч байгаагаас хөдөөгийн хүн амын 54 хувь(ойролцоогоор 593 000 хүн) амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдарч байна.¹ Монгол Улсын уул уурхайн үсрэнгүй хөгжлийн үр шим нийгмийн элит давхаргад төвлөрөн, пропорциональ бусаар хуримтлагдаж, сүүлийн жилүүдэд тэгш бус байдал гүнзгийрсээр байна.

Монгол Улс тогтвортой хөгжин дэвших нь Австрали улсын үндэсний эрх ашигт нийцэх бөгөөд манай тусламж Монгол Улсад сайн засаглал бэхжин, эдийн засаг сэргэн хөгжиж, тэгш шударга байдал хангагдахад чиглэгдэх болно. Австралийн тусламжийн хөрөнгө оруулалтыг зохистой чиглүүлэн бодитой үр дүн гаргах боломжтой бөгөөд хүний нөөцийн хөгжилд оруулж буй Австралийн тусламжийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн чадавхийг дээшлүүлэхэд амжилттай нөлөөлж, Австрали-Монголын хоёр талт харилцааг бэхжүүлсээр ирсэн билээ.

“Австрали Улсаас 2012-2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги”-д Монгол Улсын Засгийн газар болон ард түмэнд хөгжлийн зорилтуудаа биелүүлэхэд нь Австралийн тусламж хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар тодорхойлов. Бид төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, харьцангуй давуу тал, туршлага хуримтлуулсан тэргүүлэх гурван чиглэлээр Монгол Улсад хөгжлийн тусламж үзүүлэх бөгөөд эдгээр тэргүүлэх гурван чиглэл нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй хөгжлийн зорилтууд, нэн ялангуяа *“Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”* - д тодорхойлсон үндсэн чиглэлүүдтэй уялдаж байгаа юм. Тэргүүлэх гурван чиглэлийг дурдвал:

- *Хүний нөөцийн хөгжил* – бид сургалтын тэтгэлэг олгох тусламжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх замаар Монгол Улсын хүний нөөц болон манлайллыг бэхжүүлэн хувь хүмүүс, иргэдийг чадваржуулан улсын хөгжилд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх болно.
- *Хөгжлийн төлөөх уул уурхай* – бид уул уурхайн салбар дахь засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар уул уурхайн салбарын орлогыг тэгш, хүртээмжтэй хуваарилан ашиглах, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгана.
- *Эмзэг бүлгийг дэмжих* – бид хөдөөгийн сурагч хүүхдүүд, багш нар болон бусад хүн амыг өвчлөлөөс сэргийлэх зорилгоор эмзэг хүнд нөхцөлд буй хүүхдүүдийн усны хүртээмж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулна.

Эдгээр чиглэлээр үзүүлэх Австралийн тусламж нь Монгол Улсын Засгийн газартай хөгжлийн зорилтуудаа биелүүлэхэд нь хамтран ажиллаж ирсэн он удаан жилийн харилцаан дээр суурилж байна. Бид Монгол Улсын Засгийн газартай хамтран тусламжийн хөтөлбөрийн үр дүн, хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэхэд анхаарч, хүчин чармайлт гарган ажиллах болно. Тусламжийн хөтөлбөрийг олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон төрийн бус

1 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ), Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийн талаархи Үндэсний дөрөвдүгээр тайлан: Монгол Улс, 2011

байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхийн сацуу хөгжлийн түнш бусад байгууллагатай уялдаатай ажиллах зарчмыг мөрдөнө. Бид Монголын ард түмний ахуй амьдралд эерэг өөрчлөлт гаргахын тулд үр дүн гаргах, харилцан үүрэг хариуцлагаа биелүүлэх, мөнгө санхүүгийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад ихээхэн анхаарах болно.

Зураг 1. Монгол Улсын газрын зураг²



2 НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газар, Зураг зүйн хэсэг Газрын зураг № 3721 Rev. 3, 2004.

2 Хөгжлийн түншлэлийн зарчмууд

2.1 Зарчим, үүрэг амлалт

Австралийн тусламжийн үндсэн зорилго нь хүмүүс ядуурлаас гарахад нь туслахад чиглэнэ. Энэхүү тусламжийн үйл ажиллагаа нь бүс нутагт болон бусад бүс нутагт тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийг дэмжих замаар Австралийн үндэсний эрх ашигт үйлчилнэ.

Манай тусламжийн хөтөлбөр нь стратегийн таван зорилтын хүрээнд хэрэгжинэ. Үүнд: амь нас, амьдралыг хамгаалах, бүгдэд боломж олгох, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, үр дүнтэй засаглалыг бүрдүүлэн хөгжүүлэх, мөн онцгой байдал болон байгалийн гамшигтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг болно. Австрали Улс нь хөрөнгө нөөц, боломжоо үр дүнтэй, үр ашигтай ашиглан эерэг өөрчлөлт гаргаж чадах чиглэлд анхааран ажиллахын илрэл нь *“Австрали Улсаас 2012–2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги” юм. Тус стратегид тусгаснаар манай тусламжийн үйл ажиллагаа нь хүний нөөцийн хөгжил, хөгжлийн төлөөх уул уурхай болон эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.*

Түншлэгч засгийн газар тусламжийн хөтөлбөрийг хариуцаж, удирдан чиглүүлснээр хөтөлбөрийн хэрэгжилт урт удаан хугацаанд тогтвортой үр дүнд хүрдэг. Австрали Улс нь тусламжийн аливаа үйл ажиллагааг хөгжлийн түншийн тэргүүлэх чиглэл, бодлоготой уялдуулахад анхаардаг бөгөөд бид тухайн улсын нөхцөл байдал, хэрэгцээнд нийцсэн арга замыг сонгодог. Тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэх явцад үр дүнд хүрэхийн тулд эрсдэл хүлээх нь зайлшгүй байдаг тул бид тусламж шаардлагатай ядуу хүмүүст хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг үзүүлэхдээ эрсдэл, залилан мэхлэлтээс хамгаалах хатуу боловч ухаалаг эрсдэлийн удирдлагын арга барилыг баримтална.

Бид тусламжийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад гарч буй ахиц дэвшил, ололт амжилтын талаар тогтмол санал солилцон хэлэлцэж байх зорилгоор Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран Австрали, Монголын дээд түвшний уулзалт зөвлөгөөнийг жил тутам зохион байгуулна. Энэ нь бидний үр дүнд чиглэсэн харилцан итгэлцэл, ойлголцол, үүрэг хариуцлагад суурилсан харилцааг бэхжүүлж, Монгол Улсын *“Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”³⁴*-д дэвшүүлсэн зорилтууд, үүний дотор засаглалыг сайжруулж, тогтвортой уул уурхайн үйлдвэрийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Бид хөтөлбөрөө түншлэлээр дамжуулан хэрэгжүүлнэ. Манай хөгжлийн түншлэлийн зарчим нь харилцан хүлээх үүрэг хариуцлага, мөн хоёр улсын иргэд, байгууллагууд болон сонгогчдын өмнө хүлээх хариуцлагад үндэслэх бөгөөд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд тэгш оролцоход анхаарна. Австрали Улсын хүлээсэн үүрэг амлалт, хариуцлагын нэгэн чухал салшгүй хэсэг нь санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, үр дүн, гүйцэтгэлийг ил тод байлгахад оршино. Австрали Улс хөгжлийн тусламжийн үр дүнг сайтар тооцон хэмжиж, тайлагнах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, уялдаа холбоог бэхжүүлэх үүднээс хөгжлийн бүх түнш байгууллага ил тод байдлын зарчмыг баримтлан ажиллах явдлыг хөхиүлэн дэмжинэ. *“Австрали Улсаас 2012–2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги”* -ийн гол түнш байгууллага нь Дэлхийн Банк, НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ) болон Азийн Сан байна.

³⁴ Монгол Улсын Их Хурал, *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц стратеги*, 2008.

Энэ хөтөлбөрийн стратегийг боловсруулахдаа “2015-2016 оны тусламжийн хөтөлбөрийн стратеги чиглэлүүдийг тусгасан *Австрали улсын үр дүнтэй тусламжийн хөтөлбөр: Эерэг өөрчлөлт гаргах-Бодит үр дүнд хүрэх*” хэмээх Австрали Улсын Засгийн газрын тусламжийн бодлогын баримт бичгийг чиг баримжаа болгон мөрдөв. Засгийн газар энэ бодлогыг хэрэгжүүлэх үүднээс “*Тусламжийн цогц бодлогын хүрээ*”-г боловсруулж, 2015-16 онд зарцуулах хөрөнгө, хүрэх үндсэн үр дүнг тодорхойлж, Австралийн тусламжийг үр дүнтэй бөгөөд үр ашигтай хэрэгжүүлэх шинэ стандартыг тогтоосон болно. Монгол Улсад үзүүлж буй Австралийн тусламжийн үр дүн, нөлөөллийг нэмэгдүүлэх үүднээс тусламжийн хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүн, үр ашигт бид анхаарна. Австраль улс тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аливаа зохисгүй, хууран мэхлэх үйлдлийг үл тэвчих бөгөөд Монгол Улсад оруулж буй тусламж, хөрөнгө оруулалтандаа хариуцлагатай хандах зарчмыг баримтална.

2.2 Үр дүнд хамтран анхаарах нь

Австрали болон Монгол Улс нь ил тод байдлыг ханган, харилцан үүрэг хариуцлага хүлээн, үр дүнд хамтран анхаарах зарчимд үндэслэн тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно. Хоёр улс нь “*Тусламжийн үр өгөөжийн талаархи Парисын тунхаглал*” (2005), “*Аккрагийн үйл ажиллагааны хөтөлбөр*” (2008) болон “*Үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагааны талаархи Пусаны түншлэлийн гэрээ*” (2012)-нд тус тус гарын үсэг зурсан бөгөөд Монгол Улсад үзүүлэх Австралийн тусламжийг олон улсын өмнө хүлээсэн эдгээр үүрэг амлалттай нийцүүлэн хэрэгжүүлнэ.

[

Австрали Улс Монгол Улсад тусламжийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ Монгол Улсын “*Үндэсний Хөгжлийн Стратеги*”-тэй нийцүүлнэ.

Монгол Улсын Засгийн газартай зөвлөлдсөний үндсэн дээр хүрэх хөгжлийн үр дүнг тодорхойлсон тусламжийн хөтөлбөрийн стратегийн хэрэгжилтийг хянах зорилго бүхий “Үр дүнгийн үнэлгээний механизм” (ҮДҮМ)-г боловсруулан мөрдөнө. Австрали, Монгол улсын хоёр талын дээд түвшний зөвлөгөөнийг жил тутам зохион байгуулж, энэхүү хөтөлбөрийн стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянаж үнэлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг үр дүнгийн иж бүрэн үнэлгээнийн хүрээнд жил тутам баримтжуулан тусгах болно. Улмаар “*Австрали-Монголын хөтөлбөрийн жилийн үр дүнгийн тайлан*”-г АОУХА-ийн вэбсайтаар дамжуулан олон нийтэд хүргэх болно.

3 Австрали Улсаас Монгол Улсад үзүүлж буй тусламжийн орчин нөхцөл, үндэслэл

3.1 Ядуурал ба хэрэгцээ

Байгалийн хатуу ширүүн нөхцөл, газарзүйн тусгаарлагдмал байдал, санхүү хөрөнгийн хомсдол, ажилгүйдэл зэрэг нь Монгол дахь ядуурлын үндсэн шалтгаан болж байна. Монгол Улсад ядуурлын түвшин өндөр, хүн амын 39 хувь (1,092,000 хүн) амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдарч байгаагаас хөдөөд энэ үзүүлэлт 54 хувь (593,000 хүн) байна⁵. Монгол Улсын уул уурхайн үсрэнгүй хөгжлийн үр шим нийгмийн элит давхаргад эхлэн төвлөрч, пропорциональ бусаар хуримтлагдан, сүүлийн жилүүдэд тэгш бус байдал гүнзгийрсээр байна. Өдгөө Монгол Улс Хүний Хөгжлийн Индексээр 187 орноос 110-р байранд жагсаж байгаа билээ.

Монгол Улс нь Мянганы хөгжлийн үндсэн 8 зорилтын (МХЗ) зэрэгцээ бусад МХЗ-ыг хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлж буй МХЗ-ын 9 дэх зорилт “хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх” –г дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Монгол Улсын үндэсний МХЗ-ын хэрэгжилтийн явцын дөрөвдүгээр тайланд зааснаар нийт есөн МХЗ-ын долоо нь 2015 он гэхэд биелэгдэх төлөвтэй байна.⁶ Хэдийгээр сүүлийн жилүүдэд эдийн засгийн томоохон өсөлт гарч байгаа боловч ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилтын хэрэгжилт удаашралтай байна.

Бид ядуурлыг бууруулахад онцгой анхаарч байгаа тул төсөл хөтөлбөр, бодлогын зөвлөгөөнд Австралийн зүгээс зарцуулах санхүүгийн дэмжлэг нь Монгол Улсын Засгийн газарт хөгжлийн тэргүүлэх чиглэлээ хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Шилжилтийн эдийн засаг

Монгол Улс хөгжлийн чухал уулзварт ирээд байна. 2012 онд Монгол Улс албан ёсны том хэмжээний уул уурхайн салбарын хөгжил, түүнтэй холбоотой гадаадын хөрөнгө оруулалтын улмаас дэлхийд хамгийн хурдан өсч буй эдийн засагтай орны нэг болж, дундаж орлоготой улсын түвшинд хүрсэн билээ. Олон улсын валютын сангийн мэдээлснээр тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2011 онд 17,3 хувиар өссөн нь урьд өмнө байгаагүй өндөр өсөлт бөгөөд 2012 онд өсөлтийн хувь бага зэрэг буурч 12,7 болж, 2013 онд эргээд 15,7 хувь болж өсөх магадлалтай байна.⁷

Гэхдээ Монгол Улсын эдийн засгийн энэхүү өсөлт нь эрдэс баялгийн салбар болон Засгийн газрын өндөр зарлагатай холбоотой гарч байгаа тул эдийн засаг нь түүхий эдийн үнийн огцом уналтын сөрөг нөлөөнд өртөмтгий, эмзэг байна. 2008 оны сүүл, 2009 оны эхээр дэлхийн санхүүгийн хямралын үеэр ийм зүйл тохиолдсон билээ⁸. Сайн засаглал бүхий уул уурхайн салбар нь ядуурлыг бууруулахад дэмжлэг болохоос гадна Монгол Улс тусламж дэмжлэгээс хамаарах хамаарлыг багасгахад хувь нэмэр оруулж чадна. Нийгмийн салбарт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулах

5 Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Хороо, Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийн талаархи Үндэсний дөрөвдүгээр тайлан, 2011

6 НҮБХХ, Хүний Хөгжлийн Илтгэл- Тогтвортой байдал ба тэгш байдал: Бүгдийн Сайхан Ирээдүйн Төлөө, 2010.

7 Олон улсын валютын сан, Дэлхийн эдийн засгийн тойм мэдээллийн сан, 2011 оны 9-р сар.

8 Олон улсын валютын сан, Монгол Улс: Хоёрдох үе шатны хөтөлбөрийн дараах хяналт үнэлгээний хэлэлцүүлэг

замаар эрдэс баялгийн үр шимийг хүн амын өргөн хэсэгт хүртээх нөхцлийг бий болгосноор уул уурхайн салбар ядуурлыг бууруулах, эдийн засгийг өсөлтийг хурдасгах, Монгол улсын бие даан хөгжих чадварыг дэмжинэ. Монгол Улсын Засгийн газар уул уурхайн төслүүдийг хариуцлагатай хөгжүүлэн хэрэгжүүлэх нь гол зорилт байх болно гэж тодорхойлсонбөгөөд Австрали Улс уул уурхайн салбарын тогтвортой эрх зүйн орчин бүрдүүлэх талаар хуримтлуулсан арвин туршлага, мэдлэг чадвараа Монгол Улстай хуваалцах боломжтой. Нөгөө талаас уул уурхай (хууль ёсны болон хууль ёсны бус) Монгол Улсын эмзэг экологид хор хохирол учруулж байгаа учраас Засгийн газар байгаль орчны менежментийн талаар тенхикийн тусламж зөвлөгөө авах сонирхолтой байна. Уул уурхайтай холбоотой гарч буй байгаль орчны хамгийн том бэрхшээлүүд (голдуу гадаадын өмчлөлтэй) томоохон уурхайнуудаас боловсруулсан байгаль орчны менежментийн олон улсын шилдэг практикийг даган мөрдөх чадвар сул, ойлголт мэдлэг хангалтгүй, хүсэл зориг дутмаг жижиг, дунд оврын уурхайнуудтай илүүтэй холбогдон гарч байгаа билээ.

Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагаа уул уурхайн үйлдвэрлэл явагдаж буй болон явагдахгүй байгаа орон нутгийн иргэдийн хувьд сорилт, боломжийн аль алиныг нь авчирч байна. Орон нутгийн иргэдийн зарим нь шууд ажлын байртай болох, орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эсвэл уул уурхайтай холбоотой үйлчилгээ хангамжаар дамжуулан үр өгөөжийг нь нэлээд хүртэж байгаа бол нөгөө нэг хэсэг нь үр өгөөжийг хангалтгүй эсвэл огт хүртэхгүй байна. Эмэгтэйчүүд, хүүхдүүд болон уул уурхайнүйлдвэрлэл явагдаж буй орон нутагт нийт хүн амын эрүүл мэндтэй холбоотой онцлог эрсдэлүүд бий болж байна. Уул уурхайн салбар болон үйл ажиллагаа өсөн цар хүрээгээ тэлж байгаа хирээр төр засгийн байгууллагуудын нийгмийн ажилтнуудын ачааллыг нэмэгдүүлж, хүртээмж багатай болгосны зэрэгцээ шилжин суурьшигчид, ажилчдыг эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээнд бүртгэх тогтолцоонуудын чадавхи хязгаарлагдмал байна.

Хэрэгцээтэй мэргэжлийн ажиллах хүчний хомсдол, тэгш бус хөгжил ба байгалийн гамшигт өртөмтгий байдал

Монгол Улсын уул уурхайн салбар хурдацтай өсч байгаагийн хирээр төрийн болон хувийн хэвшил дэх хүний нөөц, мэргэжлийн ажиллах хүчний эрэлт хэрэгцээ үлэмж нэмэгдэж байна. Хэдийгээр суурь боловсролын үзүүлэлт өндөр байгаа ч ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиар олгож буй мэргэшил, ур чадвар төрийн болон хувийн хэвшил дэх хүний нөөцийн эрэлт хэрэгцээнээс зөрүүтэй байна. Дотоодын ба гадаадын аж ахуйн нэгж байгууллагууд болон төрийн байгууллагууд нь тухайн ажлын байранд нийцсэн боловсон хүчин олоход багагүй бэрхшээлтэй тулгарч байгаагаас харахад хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтот тусламжийг үргэлжлүүлэх шаардлага байна.

Уул уурхайн салбарын ашиг орлогын менежментийн хариуцлагатай болон ил тод байдлыг дээшлүүлснээр уул уурхайн хурдацтай өсөлтийн үр өгөөжийг хүртэх Монгол иргэдийн тоог нэмэгдүүлж, ядуурлыг үлэмж бууруулах боломжийг бүрдүүлнэ. Сүүлийн жилүүдэд ДНБ тогтвортой өсөж байгаа хэдий ч үр өгөөж, боломжуудыг ядуу иргэдэд тэгш хүртээх асуудал анхаарал татаж шийдвэрлэвэл зохих асуудал байсаар байна.

Монгол Улсын нийт 2,8 сая хүн амын 44 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрөн суурьшиж, үлдсэн хэсэг нь бусад газар уудам хээр тал, уул толгодоор тархан нутагладаг.⁹ Газарзүйн байршлын хувьд алслагдмал,хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвар сул дорой зэрэг шалтгааны улмаас хөдөөгийн хүн ам уул уурхайн салбарын түргэн өсөлтийн явцад нийгэм-эдийн засгийн хувьд доройтох эрсдэл тулгарч байна. Хөдөөгийн хүн амын 50-иас илүү хувь нь усны баталгаатай эх үүсвэрт холбогдоогүй, бараг 70 хувь нь эрүүл ахуй, ариун цэврийн хангалтгүй нөхцөлд амьдарч байна.¹⁰ Хөдөөгийн олон хүүхэд жилийн есөн сард нь сурч, амьдардаг сургууль

9 НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газар (НҮБХАЭГ), *Маргаашийн хямрал өнөөдөр: Хотжилтын хүмүүнлэгийн нөлөөлөл*, 2007.

10 Монгол Улсын Засгийн газар/ЮНИСЕФ, *Монгол Улс: Сургууль, цэцэрлэгийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах төсөл боловсруулах баримт бичиг АОУХА-ийн санхүүжилтын санал 2012-2015*, 2011.

болон дотуур байранд усан хангамж, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангахгүй байгаа нь анхаарал татсан асуудал хэвээр байна.

Зуд зэрэг байгалийн гамшиг хөдөөгийн хүн амын эмзэг байдлыг гүнзгийрүүлж, гадаад, дотоод шилжин суурьших хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд түлхэц өгч байна. Нийслэл Улаанбаатар хот болон Эрдэнэт, Дархан хот руу хөдөөнөөс нүүдэллэн ирэх хөдөлгөөн ихсэн, хотын захын дүүргүүдээр гэр барин суурьшиж хагас хотожсон гэр хорооллуудыг олноор бий болгож байна. Энэхүү төлөвлөгдөөгүй шилжин суурьших үйл явц ажлын байртай болж, хөдөлмөр эрхлэх боломжийг хумигдуулж, нийтийн үйлчилгээг үр ашигтай хүргэх эрэлт хэрэгцээ, ачааллыг нэмэгдүүлж байна.¹¹ Байгалийн томоохон гамшиг дахин тохиолдвол угаас нөөц, хөрөнгийн хомсдолд ороод байгаа нийгмийн үйлчилгээний байгууллагуудад улам их ачаалал ирж, төлөвлөөгүй шилжин суурьших хөдөлгөөнийг улам идэвхжүүлэх үр дагавартай.

3.2 Австрали Улсын үндэсний эрх ашиг

Австрали болон Монгол Улс он удаан жилийн турш хоёр талт харилцаагаа хөгжүүлж ирсэн бөгөөд энэ нь худалдаа, хувь хүмүүс хоорондын холбоо, батлан хамгаалах болон тусламжийн салбарыг хамарч байгаа билээ. Монгол Улс тогтвортой, хөгжин цэцэглэж байх нь Австрали Улсын үндэсний эрх ашигт нийцнэ. Бүс нутгийн тогтвортой байдлыг хангахын тулд нь бусад хөгжингүй улсын нэгэн адил Австрали Улс Монгол Улсыг Азийн өсөн хөгжиж буй ардчилалтай, эдийн засгийн нөлөө бүхий түнш байхад дэмжлэг үзүүлэх сонирхолтой. Тусламжийн хөтөлбөр нь Монгол Улс дахь засаглалыг сайжруулж, тэгш байдлыг хангасан хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ.

Монгол Улс "гуравдахь хөрш"-ийн бодлогоороо дамжуулан хүний эрх, ардчилал, чөлөөт зах зээлийн талаар ижил төстэй үзэл бодол бүхий бусад улс оронтой харилцаагаа хөгжүүлэх эрмэлзэлтэй байна. Мөн Монгол Улс нь Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг тэргүүлж байгаа нь төлөөллийн ардчиллыг тогтоохыг тууштай эрмэлзэж буйгаа харуулсан явдал юм.

Эдүгээ Австрали Улс Монголын уул уурхайн салбарын томоохон хөрөнгө оруулагч болсон бөгөөд Австралийн 180 орчим компани Монгол Улсад хөрөнгө оруулах боломжийг идэвхитэй хайж байгаа тухай мэдээ байна. Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Рио Тинто компани Оюутолгойн зэс, алтны уурхайн төслийн үндсэн хөрөнгө оруулагч бөгөөд энэхүү төсөл хэтдээ жил бүр 3 тэрбум ам. долларын орлого олохоор тооцоолсон нь Монгол Улсын 2010 оны ДНБ-ий гуравны нэгтэй тэнцэж байгаа юм. 2013 онд эхэлсэн Оюутолгой төслийн үйлдвэрлэл төлөвлөсний дагуу хөгжин тэлж оргил үед хүрэхдээ 3000-5000 ажлын байр бий болгоно.

Мөн Австрали болон Монгол Улс дэлхий дахины болон бүс нутгийн чанартай асуудлаар нягт хамтран ажилладаг. Манай хоёр орны хамтын ажиллагаа олон улсын энхийг сахиулах, аюулгүй байдлыг хамгаалахад онцгой анхаардаг бөгөөд Өмнөд Судан зэрэг орнуудад хоёр улсын хүчин алба хааж байгаа бөгөөд Монгол улсын энхийг сахиулах хүчний 800 гаруй ажилтан алба Өмнөд Суданд албан үүргээ гүйцэтгэсэн байна. Австрали Улс Монгол улсад зохион байгуулагддаг Хааны Эрэлд¹² энхийг сахиулагч хүчний хамтын сургуулилтанд жил бүр оролцдог.

3.3 Эерэг өөрчлөлт хийх чадавхи

Монгол улсын өнөөгийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, Австралийн тусламж өсөн тэлж байгаа энэ нөхцөлд с харахад Монгол улсын хөгжлийн шийдвэрлэх цаг үед бидэнд тусламжийнхаа үр ашиг, нөлөөллийг нэмэгдүүлэх боломж байна. Монгол Улсын *"Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого"* –д хүний нөөцийн хөгжил, засаглалыг сайжруулах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтуудыг тусгасан ба Австрали Улсаас Монгол Улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөрийг энэхүү хөгжлийн баримт бичигтэй нийцүүлэн Монгол Улсад

¹¹ НҮБХАЗГ, 2007.

¹² АНУ-тай хамтран Азийн бүс нутагт зохион байгуулж, явуулдаг энхийг сахиулах хүчний хамтарсан сургуулилт

хамгийн их тулгамдаж буй хөгжлийн асуудлуудын тодорхой хэсэгт чиглүүлэн тодорхойллоо. Ингэхдээ хуримтлуулсан туршлага, хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд, эерэг өөрчлөлт гаргах боломж зэргийг харгалзан тусламжийн чиглэлүүдийг тодорхойлсон болно.

Монголын гол хандивлагчдын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА), АНУ-ын Мянганы сорилын корпораци (МСК), Солонгосын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА) болон Азийн Хөгжлийн Банк (АХБ) зэрэг томоохон зээл, тусламжийн хандивлагчид ордог. Австрали улс нийт үзүүлж буй тусламжийн хэмжээгээрээ энэхүү жагсаалтын дунд хавьцаа жагсаж байгаа боловч, хамгийн том буцалтгүй тусламж хандивлагчдын нэг юм. Бид тусламжийн хөтөлбөрөө

Монгол Улсад хандивлагч байгууллага, түншүүдийг уялдан зохицуулах албан ёсны механизм байхгүй, тодорхой салбарын асуудлуудаар ажиллаж буй зохицуулалт хязгаарлагдмал хүрээг хамардаг. Зээл, тусламж авч байгаа хэмжээгээрээ дэд бүтэц, хөдөө аж ахуй, хөдөөгийн иргэдийн хөгжлийн асуудлууд эхний байранд жагссдаг ба боловсролын салбар удаах байранд орж байна. Австрали Улсад хандан Монголын хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хүсэлт нэлээд гаргадаг ба р энэ салбарт бидэнд арьцангуй давуу тал бий. Гэхдээ ч Монголын хөдөө аж ахуйн салбарт Япон, БНХАУ зэрэг орон их хэмжээний дэмжлэг үзүүлж байна. Харин уул уурхайн салбат хэдийгээр олон хандивлагч байгууллага түншүүд олноор орж ирж эхэлж байгаа ч тусламж дэмжлэг туслалцаа, санхүүжилт үзүүлэх шаардлагатай орон зай, эрэлт хэрэгцээ нэлээд байна. Энэ салбарт Монгол Улстай хуваалцах мэдлэг, туршлага бидэнд үлэмж бий.

Австрали Улс хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр тэргүүлэх хандивлагч юм. Бид 2003 оноос хойш ихээхэн нэр хүнд бүхий Монгол-Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан Монголын 234 иргэнд Австралид суралцах тэтгэлэг олгосон бөгөөд олон төгсөгчдийн зарим нь засгийн газарт өндөр албан тушаал хашиж, дийлэнх нь төрийн алба, иргэний нийгэм болон хувийн хэвшилд ажиллан Монгол Улсын хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна. Боловсролын салбарт олсон энэхүү өндөр амжилт, нэр хүндээс гадна Монгол Улсын улсын болон хувийн хэвшилд тулгарч буй хүний нөөцийн эрэлт хэрэгцээ, тулгамдсан асуудал зэргийг харгалзан үзэж бид хүний нөөцийн хөгжлийн асуудлаар тусламж дэмжлэгээ үргэлжлүүлэх болно.

Австрали Улс уул уурхайн салбарт дэлхийд тэргүүлэгч улс бөгөөд Монгол Улсын хувьд эрдэс баялгийн нөөцийг ашиглах, хөгжүүлэх загвар улсад тооцогддог. Австралийн Засгийн газрын “Хөгжлийн төлөөх уул уурхай санаачлага” нь хөгжиж буй орнууд байгалийн баялгаа ашиглан эдийн засгаа тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн тусламж үзүүлдэг хөтөлбөр билээ. Энэ санаачлагыг бид Монгол Улсад хэрэгжүүлэн олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд, хөгжлийн бусад түнштэй хамтран ажиллах замаар Монгол Улсын Засгийн газарт уул уурхайн үр өгөөж, боломжийг дээд зэргээр нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг туслалцааг үзүүлэх болно. Хөгжлийн төлөөх уул уурхай санаачлагыг хэрэгжүүлэхдээ бид засаглал, ил тод байдлыг сайжруулж, уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах бодлого, хөтөлбөрийг дэмжихэд анхаарах болно. Австрали Улс уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа говийн өмнөд бүсийн аймгуудад гүний усны менежментийн үйл ажиллагааг дэмжин дөрвөн жилийн хугацаанд 5 сая австраль долларын тусламж үзүүлэх болно.

Түүнчлэн Австрали Улс эмзэг бүлгийнхнийг дэмжихэд ихээхэн анхаарч төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Бид Улаан загалмайн нийгэмлэг, түүний салбар байгууллагууд болон НҮБ-ын Хүүхдийн Сан зэрэг олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран байгалийн гамшгийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж ирсэн бөгөөд хөдөөгийн алслагдмал нутгийн иргэдийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг (WASH) сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. Бидний дэмжлэгтэйгээр 2012 онд Монгол Улсын хамгийн алслагдмал аймгуудын нэг болох Хөвсгөл¹³ аймагт (1-р зургийг үзнэ үү) нийт 3,4 сая ам долларын санхүүжилт бүхий төсөл хэрэгжиж байна. Тус төслөөр сургууль, дотуур байрны усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулснаар 7800 орчим хүүхэд ус, ариун цэвэр, эрүүл

ахуйн хангамжийн сайжруулсан нөхцөлд суралцаж, амьдрах болно. Түүнчлэн бид уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй болон явагдаагүй хөдөө орон нутгийн зарим газарт эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн дэмжлэг туслалцаа үзүүлэх болно.

3.4 Цар хүрээ ба үр ашиг

Австрали Улс Монгол Улсад үзүүлж буй тусламжаа өөрийн харьцангуй давуу тал бүхий тэргүүлэх цөөн чиглэлд төвлөрүүлснээр аль хэдийн эерэг үр дүнд хүрч чадсан билээ. Австрали Улс тусламжаа өргөжүүлэхийн хэрээр энэ зарчмаа чанд баримтална. Бид цаашдаа “Эерэг Өөрчлөлт Хийх- Бодит Үр дүн гаргах” - тусламжийн хөтөлбөрийн дагуу хамгийн их эерэг өөрчлөлт гаргаж чадах, урьд өмнө нь амжилттай сайн хэрэгжүүлж үр дүнд хүрсэн тэргүүлэх гурван чиглэлд төвлөрүүлэн тусламжийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх болно. Хүний нөөцийн хөгжил, хөгжлийн төлөөх уул уурхай, эмзэг бүлгийнхнийг дэмжих эдгээр гурван чиглэл нь АОУХА-ийн дэлхий даяар баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын Засгийн газартай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлсон хөгжлийн тэргүүлэх чиглэл, Монгол Улсад одоо хэрэгжүүлж байгаа АОУХА-ийн хөтөлбөрийн агуулга гурвын уулзварыг илэрхийлж байгаа билээ.

Бид дэд бүтэц, хөдөө аж ахуй зэрэг бусад салбар, тэргүүлэх чиглэлд хөгжлийн бусад түнш хэдийн томоохон хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгааг харгалзан үзсэний үндсэн дээр эдгээр салбар, чиглэлд тусламж хандуулахгүй байх стратегийн шийдвэр гаргав. Монгол-Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх “Хүний нөөцийн хөгжил” нь төрийн болон хувийн хэвшилд үлэмж хэрэгцээтэй байгаа хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хоёр талт харилцааг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа бол цаашид цар хүрээ нь өргөжин тэлэх “Хөгжлийн төлөөх уул уурхай” Монгол Улсын хэрэгцээнд үндэслэн энэ чиглэлээр Австрали улсын өндөр чадамж, чадавхийг ашиглан эерэг өөрчлөлт гаргах зорилтыг агуулж байна. “Эмзэг бүлгийг дэмжих”-д бид анхаарал хандуулан тусламж үзүүлэх хэдий ч нийт санхүүгийн дэмжлэгийн нэлээд хэсгийг “Хүний нөөцийн хөгжил” болон “Хөгжлийн төлөөх уул уурхай”-д олгоно. Учир нь энэ хоёр чиглэлээр бид үр ашигтай ажиллаж, бодит үр дүн гаргах өндөр чадавхи бидэнд бий.

4 Австрали Улсын тусламжийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд

4.1 Голлон анхаарахаар санал болгож буй чиглэлүүд, гарах үр дүн ба Австрали улсаас оруулах хувь нэмэр

Монгол Улс дахь бидний үйл ажиллагаа гурван үндсэн сэдвийн хүрээнд явагдана. Үүнд :

1. Хүний нөөцийн хөгжил;
2. Хөгжлийн төлөөх уул уурхай;
3. Эмзэг бүлгийг дэмжих.

Эдгээр сэдэв нь нь “Австралийн үр нөлөөтэй тусламжийн хөтөлбөр: Эерэг өөрчлөлт хийх, бодит үр дүнд хүрэх” хэмээх баримт бичигт заасан стратегийн таван зорилтын хоёрыг нь тусгасан болно. Үүнд:

- Сургууль, цэцэрлэгийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг шийдвэрлэснээр боловсролын үйлчилгээг илүү олон хүүхдэд хүргэх, төрийн алба хаагчид, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудад ажиллагсдыг магистрын түвшний сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх замаар **бүгдэд боломж олгох**-
- Уул уурхайн байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, уул уурхайн салбар дахь хариуцлага болон ил тод байдлыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын үр өгөөжийг Монгол Улсын бүх иргэнд хүртээх явдлыг дэмжих замаар **эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох**
- Монгол Улсын төр, засгийн газрын байгууллагууд, тухайлбал улсын болон орон нутгийн төр, засгийн газрын байгууллагуудын чадавхийг сайжруулах замаар үр дүнтэй засаглалыг дэмжих

Манай тусламжийн хөтөлбөрт жендэрийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах хөгжлийн зарчим, хандлагыг тусгасан болно.

1. Хүний нөөцийн хөгжил

Хүний нөөцийн хөгжил нь Австрали Улсаас Монгол Улсад үзүүлж буй тусламжийн гол чиглэл байсаар ирсэн бөгөөд чанар, ач холбогдлын хувьд тус улсад өндрөөр үнэлэгддэг. Хүн ам багатай, эдийн засгийн өндөр өсөлттэй орчинд Монгол Улсын төрийн алба нь ялангуяа шинэчлэлийн үйл явцыг хэрэгжүүлэх явцад хүний нөөцийг сайжруулах асуудал ихээхэн анхаарал татаж байгаа билээ. Төрийн албан хаагчид уул уурхайн салбарын түргэн өсөлттэй уялдан гарч буй төрийн өргөн хүрээг хамарсан удирдан зохицуулах үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхдээ асар их ачаалалтай ажиллаж байна. Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн байгууллагуудын зүгээс удирдах ажлын авьяас чадвартай мэргэжилтнүүдийг идэвхтэй хайж байгаатай холбоотойгоор цалин хөлсний түвшин нэмэгдэж, өндөр чадвартай боловсон хүчний эрэлт хэрэгцээ ихэссээр байна. Ийм асуудал бүх салбарт тохиолдож байгаа бөгөөд Засгийн газрын бараг бүх яамдыг хамарч байна.

Монгол Улсын удирдах ажилтны нөөцийг нэмэгдүүлэхэд дээд боловсролын сургалт чухал ач холбогдолтой бөгөөд Австрали улсаас хэрэгжүүлж буй тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан энэхүү хэрэгцээ шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах бүрэн боломж бий. Монгол Улсын хүний

нөөцийн хөгжлийг дэмжих Австрали улсын гол үйл ажиллагаа болох Монгол-Австралийн тэтгэлэгт хөтөлбөр нь Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн салбаруудын хүний нөөцийг хөгжүүлэх, Австрали-Монголын хооронд мэдлэг солилцох, байгууллагууд холбоо харилцаа тогтоох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Монгол Улсын “*Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*” --д нийцүүлэн эрүүл мэнд, уул уурхай, боловсрол, байгалийн нөөцийн менежмент зэрэг чиглэлээр төрийн болон хувийн хэвшилд ажиллаж буй Монгол Улсын иргэдэд магистрын шатны сургалтын тэтгэлэг олгож байна. 2012 оноос эхлэн жил бүр 38 хүн тус хөтөлбөрөөр Австралид магистрын шатны сургалтад хамрагдаж байна.

2. Хөгжлийн төлөөх уул уурхай

Монгол Улсын Засгийн газар уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах нь үндсэн шаардлага гэж тодорхойлсны дагуу Австрали Улсын тусламж хөгжлийн төлөөх уул уурхай хөтөлбөр хэрэгжүүлэн энэ чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. 2013 оны дунд үе гэхэд эцэслэн боловсруулах тус хөтөлбөр гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд :

1. *Уул уурхайн бодлого боловсруулах ба хэрэгжүүлэх* – Монгол Улсын уул уурхайн салбарыг удирдах, зохицуулах, хянах үүрэг бүхий засгийн газрын байгууллагуудад богино хугацааны сургалт явуулж, техникийн тусламж үзүүлэхэд анхаарна.
2. *Уул уурхайн байгаль орчны нөлөөлөл* – АОУХА-ийн уул уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаан дээр суурилна. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийг Дэлхийн Банктай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Австралийн ирээдүйд үзүүлэх тусламж дэмжлэгийн үйл ажиллагааг тодорхойлох үүднээс Дэлхийн Банк 2013 онд уул уурхайн байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ явуулах саналтай байна.
3. *Уул уурхайн нийгмийн нөлөөлөл* – уул уурхайн нийгмийн зарим нөлөөлөл, үүний дотор уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй бүс нутагт эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломж зэрэг асуудлыг хамарна

3. Эмзэг бүлгийг дэмжих

Австрали улс Монгол Улсын алслагдмал аймгуудын хүн амд чиглэсэн тусламжийн үйл ажиллагаа явуулж байгаагийн нэг нь НҮБ-ын Хүүхдийн Сантай тогтоосон түншлэлийн харилцааны хүрээнд 2012 лглс эхлэн хэрэгжүүлж буй төсөл болно. Тус төсөл Монгол улсын баруун хойд хэсэгт орших Хөвсгөл аймгийн сонгогдсон сумдад хүүхдүүдийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулахад чиглэж байна. Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийн хүртээмжийг сайжруулах асуудалд анхаарал тавьж шийдвэрлэх хэрэгцээтэй байгаа бөгөөд энэ нь эмзэг бүлгийг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болно. Ийнхүү алслагдмал хөдөө орон нутгийн эмзэг бүлгүүдэд чиглэсэн тусламжийн үйл ажиллагаанаас гадна Улаанбаатар хотын захын хорооллуудад ус, цахилгаан, ариун цэвэр зэрэг суурь үйлчилгээнүүдийн хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Энэ чиглэлээр Азийн Сантай хамтран ажиллана.

Хөгжлийн төлөөх уул уурхай хөтөлбөрийн гуравдах бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд (*Уул уурхайн нийгмийн нөлөөлөл*) сайн дурынхны хөтөлбөр, Австралийн хөгжлийн судалгааны тэтгэлгийн хөтөлбөрөөр дамжуулан эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлнэ. Австрали Улс болзошгүй байгалийн гамшгийн үеэр Монголын болон олон улсын түншүүдээрд дамжуулан хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд бэлэн байх болно.

4.2 Хөтөлбөрийн хандлага ба ажиллах арга зам

“Австрали Улсаас 2012–2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги” нь одоогийн хөтөлбөрийн хэрэгжилтийн амжилт дээр тулгуурлан шинээр гарч ирж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд ач холбогдол болон чиглэлүүдээр зарим өөрчлөлт хийх шаардлагатай байж болохыг харгалзан үзнэ. Цөөн тооны тодорхой салбаруудад цөөн тооны гэхдээ томоохон хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх замаар тусламжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах бодлогын хүрээнд бид туршлага, мэдлэгийн давуу талаа ашиглан дээд зэргээр эерэг өөрчлөлт гаргахад чиглэн ажиллах болно. Түүнчлэн салбарын хүрээнд болон стратеги, хэрэгжилтийн бүх түвшинд уялдаа холбоог хангах үүднээс бид Монгол Улсын Засгийн Газар, иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад хандивлагч нартай хамтран уялдаатай ажиллах болно.

Монгол Улсын Засгийн газартай бат бөх харилцаагаа хадгалахын зэрэгцээ бид дараах талуудтай хамтран ажиллах болно:

- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд чухал түншэд тооцогдох Дэлхийн Банк, НҮБ-ын байгууллагууд зэрэг *олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд болон хоёр талт хандивлагчидтай болон олон талт хамтран ажиллана*. Австрали Улс Монгол Улсын Засгийн газар, хоёр талт болон олон талт олон улсын хандивлагчдын хооронд явуулдаг жил тутмын Хөгжлийн түншүүдийн уулзалтад идэвхтэй оролцдог бөгөөд хандивлагчдын үйл ажиллагааг цаашид улам сайжруулан уялдуулахыг бид дэмжсээр байх болно.
- Бодлогод эерэгээр нөлөөлж, өөрчлөлт хийхэд чиглэн нэгдэж, хамтарч ажиллах шинэлэг арга, хандлага баримталж буй иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэнтэй хамтарч ажиллана. Тэрээр хөгжлийн тодорхой үр дүнд хүрэхээр хүчээ нэгтгэн хамтран ажиллаж буй иргэний нийгэм, хувийн хэвшил, засгийн газрын төлөөлөгчдийг бид дэмжих болно. Тухайлбал, *төрийн бус байгууллагууд* нь орон нутагт хүрч ажиллах боломж сайтай, орон нутгийн хөгжлийн асуудлаар ажиллах туршлагатай учир төсөл хэрэгжүүлэх чухал түншүүд юм.
- *Австралийн Засгийн газрын болон боловсрол, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллана*. Манай тусламжийн хөтөлбөр эдгээр харилцаан дээр тулгуурлах бөгөөд зорилтот экспертиз, техникийн тусламжийг тухайн чиглэлийн Австралийн байгууллагаар дамжуулан үзүүлнэ.
- Австралийн Олон улсын хөгжлийн төлөө сайн дурынхны хөтөлбөрийн шугамаар ирэх *сайн дурын ажилтнууд* нь “Австрали Улсаас Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги 2012–2016”-д заасан уул уурхай, засаглал, байгаль орчин, эмзэг бүлгийг дэмжих тэргүүлэх чиглэлд нийцсэн салбаруудад ажиллана.
- Хүний нөөцийн хөгжил зэрэг салбарт хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад *менежментийн гэрээт гүйцэтгэгчидтэй* хамтран ажиллана.
- Австрали Улсын Тусламжийн Бодлогын Дагуу манай хөгжлийн түншүүд Австрали Улсаас үзүүлэх санхүүгийн хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, мэдээлж байхыг бид хүсэж байна. Энэ нь Австралийн ард түмний өмнө болон Австралийн тусламжийг авч буй ард түмний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын нэг чухал хэсэг болж, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлнэ.

5 Хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүн ба эрсдэлийн удирдлага

5.1 Стратегийг хэрэгжүүлж дуусахад ямар амжилтад хүрсэн байх вэ

Австралийн үйл ажиллагааны амжилтыг “Австрали Улсаас 2012–2016 онд Монгол Улсад Хэрэгжүүлэх Хөтөлбөрийн Стратеги”-д заасан тэргүүлэх гурван чиглэлийн дагуу гаргасан ололт, үр дүн, гүйцэтгэлээр хэмжинэ. Бид 2016 он гэхэд дараах үндсэн үр дүнд хүрэхээр тодорхойлж байна:

- *Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлсэн байна:* Монголоос 190 хүн Австралид суралцаж, дээд боловсрол эзэмшсэн байна. Шинэ түншлэлийн харилцаа холбоо тогтоогдож, Монгол, Австралийн төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоо улам бэхжсэн байна.
- *Монгол Улсын уул уурхайн салбарын хариуцлага, ил тод байдал, засаглалыг бэхжүүлсэн байна:* Монгол Улсын эрх баригчдын байгалийн нөөцийн ашиглалтыг идэвхитэй зохицуулах, хянах, байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чадавхи сайжирсан байна.
- *Усан хангамж, ариун цэврийн нөхцөл сайжирсан байна:* Монгол Улсын баруун хойд хэсэгт орших Хөвсгөл аймгийн 12 сургууль, 12 цэцэрлэгт Австрали Улсын санхүүжилтаар усан хангамж, ариун цэврийн болон гар угаах байгууламж барьж байгуулснаар хөдөөгийн 7800 орчим хүүхдийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл сайжирсан байна. Үүний зэрэгцээ, багш, хүүхдүүдэд ариун цэвэр, эрүүл ахуйн сургалт явуулснаар сурагчид, 840 орчим багш, ажилчид болон тухайн орон нутгийн иргэд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

5.2 Үр дүнгийн үнэлгээний механизм

Хяналт, үнэлгээ нь үр дүнтэй тусламжийн стратегийн нэг чухал хэсэг нь болдог. Бид түншүүдийн хамтаар хөтөлбөрийн хэрэгжилтийн ахиц дэвшил, явцыг үндсэн, стратегийн хүрэх үр дүнтэй харьцуулан жил тутам хянан үнэлгээ хийж байх болно. Манай хөтөлбөрүүдэд шаардлагатай бол өөрчлөлт, тодотгол хийх уян хатан байр суурийг баримтална. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн явцыг хэмжих талаар тодорхой тусгасан үр дүнгийн үнэлгээний механизмыг 2013 онд хэвлэн гаргах болно.

5.3 Эрсдэлийн удирдлага

Энэ хөтөлбөрийн стратегийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн дөрвөн эрсдэл саад учруулах магадлалтай. Үүнд: Засгийн газрын чадавхийн бүтэц, эдийн засгийн савалгаа, хөтөлбөрийг хэт олон хэсэгт хувааснаар тарамдуулах, хандивлагчдын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул байгаа зэрэг болно. Эдгээр дөрвөн үндсэн эрсдэлийг зохицуулах арга хэмжээг дор дурдав. Үүнд:

Засгийн газрын чадавхийн бүтэц

2012 оны сонгуулиар Монгол Улсын Засгийн газарт томоохон өөрчлөлтүүд гарсны дотор тусламжийн асуудал нь чиг үүргийн хувьд шинээр байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжсэн болно. Эдгээр өөрчлөлт нь Монгол Улсын хэт ачаалалтай ажиллаж буй төрийн албаны ачааллыг ихэсгэхэд нөлөөлж байна.

Бид шинээр бүрдсэн Засгийн газрын удирдлага, албан тушаалтнуудыг Австралийн тусламжийн хөтөлбөрийн талаар бүрэн мэдээллээр хангаж, тэдэнтэй нягт холбоотой байх үүднээс Эдийн засгийн хөгжлийн яамтай байнгын харилцаатай ажиллах болно. Ингэснээр манай хөтөлбөрийн өргөжих явцыг үр дүнтэй зохицуулан хэрэгжүүлэх, хоёр орны засгийн газар хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжихэд хариуцлагатай хандах явдлыг дэмжих болно.

Эдийн засгийн савалгаат байдал

Засгийн газрын чадавхийн бүтэц, эдийн засгийн тогтвортой байдал хоёр хоорондоо өвөрмөц холбоотой. Монгол Улсын Засгийн газарт чадавхийн бүтцээ бэхжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх нь ардчилсан ололт амжилтыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах төдийгүй хөрөнгө оруулалтын баталгаат байдлыг хөхиүлэн дэмжих болно. Нийгэм, эдийн засгийн эрүүл, таатай орчин уул уурхайг өргөжүүлж, эдийн засгийн өсөлтийг улам тогтвортой болгоно.

. Бид “Тусламжийн цогц бодлогын хүрээ”-нд ажиллаж, түншлэгч тал болох Эдийн засгийн хөгжлийн яамтай ил тод харилцаатай байх замаар тусламжийн хөтөлбөрийн санхүүжилтыг урьдчилан тооцож, Австрали, Монгол хоёр улсын засгийн газрын хувьд тусламжийн хөрөнгө оруулалтыг илүү тодорхой болгоно.

Хөтөлбөрийг хэт олон хэсэгт хувааснаар тарамдуулах

Монгол Улстай тогтоосон Австралийн хөгжлийн түншлэл байр сууриа олж, өргөжихийн хэрээр АОУХА-ийн хөрөнгө, нөөцийн эрэлт улам нэмэгдэнэ. Тусламжийн менежментээ үр дүнтэй байлгаж, хөтөлбөрөө хэт олон хэсэгт хуваан тарамдуулахгүйн тулд бид цөөн чиглэлээр стратегийн хөрөнгө оруулалт хийх болно. Бид одоо байгаа сүлжээ, нарийн мэдлэгтэй мэргэжилтнүүдээр дамжуулан нөлөөллөө тэлэх зорилгоор хөтөлбөрөө үргэжлүүлэн олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Хандивлагчдын уялдаа муутай сул хамтын ажиллагаа

Монгол Улсад хөгжлийн идэвхитэй түншүүд олон байгаатай холбоотой тусламж давхардах, уялдаа сулрах, Монгол Улсын Засгийн газрын менежментийн зардал өсөх зэрэг эрсдэл гардаг. Энэ нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах зэрэг илүү чухал үйл ажиллагаанаас түнш засгийн газрын менежментийн хязгаарлагдмал нөөцийг холтгон өөр чиглэл рүү оруулж болзошгүй. Австрали улс хөгжлийн түншүүд, үүний дотор хоёр талт болон олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын аль алинтай нь нягт хамтран ажиллахдаа үүрэг, хариуцлагаа тодруулж, харилцаа холбооны сувгийг бий болгоно.

Олон талт олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас хамаарах хамаарлыг хэт их болгож, улмаар манай хөтөлбөрийн нэр хүнд болон үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт хязгаарлагдахаас сэргийлэх үүднээс эдгээр байгууллагатай тогтоосон одоогийн хамтын ажиллагааг тэнцвэржүүлэх хэрэгтэй болно. Дээрх асуудлаас сэргийлэх зорилгоор бид хамтын үйл ажиллагаагаа боловсруулах, хянах, үнэлэх, шошголохдоо өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон талт түншүүдтэйгээ хамтран ажиллаж эхлээд байна.

6 Лавлах материал

Монгол Улсын Их Хурал, *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*, 2008.

Монгол Улсын Засгийн газар/НҮБ-ын Хүүхдийн Сан, *Монгол Улс: Сургууль, цэцэрлэгийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах төсөл боловсруулах баримт бичиг* АОУХА-ийн санхүүжилтын санал 2012-2015, 2011.

Олон улсын валютын сан, *Дэлхийн эдийн засгийн тойм мэдээллийн сан*, 2011 оны 9-р сар.

Олон улсын валютын сан, *Монгол Улс: Хоёрдахь удаагийн хөтөлбөрийн дараах мониторингийн хэлэлцүүлгүүд*, 2012.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, *Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэл*, 2011.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, *Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаархи Үндэсний гуравдахь тайлан: Монгол Улс*, 2010.

НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газар (НҮБХАЗГ), *Маргаашийн хямрал өнөөдөр: Хотжилтын хүмүүнлэгийн нөлөөлөл*, 2007.

НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газар, *Зураг зүйн хэсэг Газрын зураг № 3721 Rev. 3*, 2004.